

БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТЭЭС СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ (2027-2030)



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ



МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙН
ГАЗАР



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



World Organisation
for Animal Health
Founded as OIE



World Health
Organization



Food and Agriculture Organization
of the United Nations



МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын эдийн засаг, хүнсний аюулгүй байдал, үндэсний уламжлалт соёлын чухал тулгуур нь мал аж ахуй юм. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах, мөн бичил биетний тэсвэржилтээс урьдчилан сэргийлэхэд мал эмнэлгийн салбар чухал үүрэг гүйцэтгэдэг.

Бичил биетний тэсвэржилт (ББТ) нь хүн, амьтан, ургамал болон хүрээлэн буй орчны эрүүл мэндэд нөлөөлж буй дэлхий нийтийн тулгамдсан асуудал болоод байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2024 оны 79 дүгээр чуулганаар улс орнуудын удирдагчид энэ асуудлыг хэлэлцэн, салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, хамтран үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатайг онцлон тэмдэглэсэн. Монгол Улс энэхүү чиглэлд олон салбарын хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлэн ажиллаж байна.

Мал Эмнэлгийн Ерөнхий Газар нь “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” болон “Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай” хуулийн хэрэгжилтийн хүрээнд мал, амьтны эмийн үйлдвэрлэл, импорт, худалдаа, хэрэглээний зохицуулалт, хяналтыг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тухайлбал, мал, амьтны эмийг жороор олгох журмыг нэвтрүүлж, бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг дэмжих тогтолцоог бүрдүүлсэн. Мөн мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн дэх эмийн үлдэгдэл болон бичил биетний тэсвэржилтийн тандалтыг тогтмол зохион байгуулж, эрсдэлийн үнэлгээ хийж байна.

Манай орны бэлчээрийн мал аж ахуйн нөхцөлд бичил биетний эсрэг эмийн хэрэглээ харьцангуй бага байгаа нь эерэг үзүүлэлт боловч алслагдсан сум, багт,

орон нутагт мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмж дутмаг, олон нийтийн мэдлэг, ойлголт хангалтгүй байгаа нь эмийн зохисгүй хэрэглээ үүсэх эрсдэлийг бий болгож байна. Иймээс бичил биетний тэсвэржилттэй тэмцэхэд зөвхөн эрх зүйн зохицуулалт, тандалт хангалтгүй бөгөөд олон нийтийн мэдлэг, хандлага, зан үйлийн өөрчлөлтийг дэмжих мэдээлэл, харилцаа, боловсролын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

“Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх, тэмцэх мэдээлэл харилцааны үндэсний стратеги (2027–2030)” нь энэ чиглэлд хэрэгжүүлэх бодлогын чухал баримт бичиг бөгөөд “Нэг эрүүл мэнд” хандлагад тулгуурлан боловсруулагдсан болно. Энэхүү стратеги нь салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг дэмжих, улмаар зан үйлийн тогтвортой

өөрчлөлтийг бий болгоход чиглэж байна.

Иймд малын эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, фермер, малчид, бодлого боловсруулагчид, судлаачид, багш сурган хүмүүжүүлэгчид, хөгжлийн түнш байгууллагууд болон нийт иргэд та бүхнийг энэхүү стратегийг идэвхтэй дэмжин хэрэгжүүлэхийг уриалж байна. Бичил биетний тэсвэржилттэй тэмцэх нь салбар хоорондын хамтын хариуцлага бөгөөд бид хамтран ажилласнаар мал, амьтны болон нийтийн эрүүл мэндийг хамгаалж, Монгол Улсын тогтвортой, аюулгүй ирээдүйг бүрдүүлэх боломжтой.

Басангийн Батсүх

Мал Эмнэлгийн Ерөнхий Газрын дарга
Монгол Улсын Ерөнхий Малын Эмч
Дэлхийн Мал, Амьтны Эрүүл Мэндийн
Байгууллагын Монгол Улс дахь төлөөлөгч



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Бичил биетний тэсвэржилт (ББТ) нь орчин үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгамдаж буй асуудлын нэг юм. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд бичил биетний эсрэг эмчилгээний зөв менежмент, үр нөлөө нь халдварт өвчний, эрчимт эмчилгээний, эх, хүүхдийн, хавдрын эмчилгээний идэвхийг сайжруулах, мэс засал үр дүнтэй болоход үндэс суурь болдог. Гэвч эдгээр эмийн үр нөлөө буурах үед зөвхөн эмчилгээний зардал өссөнөөр хязгаарлагдахгүй, өвчний явц удаашрах, хүндрэл, эрсдэл ихсэх, урьдчилан сэргийлэх боломжтой нас баралт нэмэгдэх зэрэг сөрөг үр дагаварт хүргэдэг.

Монгол Улсад хийгдсэн тандалт судалгааны мэдээллээс үзэхэд бичил биетний эсрэг эмийн хэрэглээ дэлхийн дундажтай харьцуулахад манай оронд өндөр түвшинд хэвээр байгаа бөгөөд ДЭМБ-ын AWaRe ангиллын "Watch" бүлгийн антибиотикийн хэрэглээ нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Үүний зэрэгцээ бичил биетний эсрэг эмчилгээ шаардлагатай эмчлүүлэгч бүрд эмийн мэдрэг чанарын шинжилгээг хийж эмчилгээний менежментэд хэрэглэж бүрэн төлөвшөөгүй байгаа нь нотолгоонд суурилсан эмчилгээний шийдвэр гаргалт,

жор бичилтийг хязгаарлаж, эмчилгээний үр дүнд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болсоор байна. Мөн эмнэлгээс шалтгаалах халдварын түгээмэл үүсгэгч нянгуудын тэсвэржилтийн түвшин өндөр байгаа нь манай улсын эрүүл мэндийн тогтолцоонд бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээ, тандалт, хяналтын тогтолцоог улам бэхжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Эдгээрээс дүгнэвэл, бичил биетний эсрэг чанар, аюулгүй байдал нь өндөр түвшний эмээр зах зээлийг хангахын зэрэгцээ тэдгээрийг зохистой, хариуцлагатай хэрэглэх дадлыг төлөвшүүлэх шаардлагатай байна. Бид цаашид салбар дундын зохицуулалтыг сайжруулах, жороор олгох стандартын хэрэгжилтийг хангуулах, эмийн аюулгүй байдлын тандалтыг бэхжүүлэх, ханган нийлүүлэлтийн сүлжээний хяналтыг сайжруулах, өвчний оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн зааврын хэрэгжилтийг хангах нь эдгээр эмийн үр нөлөөг хадгалж хамгаалах үндсэн тулгуур хүчин зүйлс юм.

Бичил биетний тэсвэржилтийн мэдээлэл, харилцааны стратеги (2027–2030) нь эмч,

эм зүйч, эрүүл мэндийн ажилтан, бодлого боловсруулагч болон олон нийтийг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах, улмаар мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор боловсруулагдсан. Мэдээлэл, харилцаа нь зөвхөн мэдээлэл түгээх үйл явц төдий бус, зөв хандлага, ойлголтод нөлөөлөх, мэргэжлийн хариуцлагыг бэхжүүлэх, зан үйлийн өөрчлөлтийг дэмжих стратегийн чухал хэрэгсэл юм. Энэхүү стратеги нь зорилтот сурталчилгаа, мэргэжлийн сургалтыг ил тод мэдээлэл солилцооны хэрэгслээр дамжуулан эрүүл мэндийн салбарт бичил биетний эсрэг эмийн хариуцлагатай, зохистой хэрэглээний соёлыг төлөвшүүлэхэд чиглэнэ.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын хувьд би зохицуулалтын орчныг бэхжүүлэх, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих, эрүүл мэндийн байгууллагуудад бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээний хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд онцгойлон анхаарч ажиллаж байна. Үүний хүрээнд Эрүүл мэндийн яам, мэргэжлийн холбоод,

эрдэм шинжилгээний байгууллагууд болон олон улсын түнш байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, Монгол Улсын бичил биетний тэсвэржилтийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь нотолгоонд суурилсан, салбар дундын уялдаа холбоотой, тогтвортой хэрэгжих нөхцөлийг хангахыг зорьж байна.

Бичил биетний тэсвэржилтийг бууруулах болон Бичил биетний эсрэг эмийн эмчилгээний үр нөлөөг хамгаалах нь зөвхөн өнөөгийн эрүүл мэндийн салбарын зорилт бус, харин ирээдүй хойч үедээ хүлээсэн бидний хамтын хариуцлага юм. Хамтын үүрэг амлалт, мэргэжлийн ёс зүй, мэдээлэлд суурилсан олон нийтийн оролцоонд тулгуурлан бид эдгээр амин чухал эмийн үр нөлөөг хадгалснаар, Монгол Улсын иргэдэд илүү аюулгүй, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх боломжийг бүрдүүлж чадна.

Пүрэвэгийн Алтанцэцэг

Клиникийн профессор
Эм, Эмнэлгийн Хэрэгслийн Хяналт,
Зохицуулалтын Газрын дарга



World Organisation
for Animal Health
Founded as OIE



Бичил биетний тэсвэржилт (ББТ) нь хүн, мал амьтан болон хүрээлэн буй орчны эрүүл мэндэд нөлөөлж байгаа дэлхийн хэмжээнд өсөн нэмэгдэж буй аюул занал юм. Үүнтэй тэмцэхэд салбар хооронд уялдаа холбоотой, тасралтгүй хамтын ажиллагаа шаардлагатай. Монгол Улс энэ чиглэлд тууштай үүрэг амлалт гарган, бичил биетний эсрэг эмийн хэрэглээний бодлогоо бэхжүүлж, “Нэг эрүүл мэнд” хандлагад нийцсэн салбар дундын хамтын ажиллагаа явуулж байна.

2024 онд Дэлхийн Мал, Амьтны Эрүүл Мэндийн Байгууллага нь Мал Эмнэлгийн Ерөнхий Газар (МЭЕГ) болон үндэсний түнш байгууллагуудтай хамтран ажиллаж, ББТ-тэй тэмцэх Монгол Улсын үндэсний мэдээлэл харилцааны чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааг үнэлж, тэргүүлэх чиглэлийн арга хэмжээнүүдийг хамтран тодорхойлсон. Улаанбаатар хотод

зохион байгуулсан үндэсний семинарын үеэр хүн, мал амьтан, хүрээлэн буй орчны эрүүл мэндийн салбарын оролцогч талууд мэдээлэл харилцааны сул талууд, шийдлүүд болон үр дүнтэй мэдээлэл дамжуулах сувгуудыг тодорхойлж, эдгээр нь энэхүү Үндэсний мэдээлэл харилцааны стратегийг боловсруулахад шууд тусгалаа олсон.

Энэхүү стратеги нь Монгол Улсад ББТ-ийн талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах, бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг дэмжих, салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлэхэд чиглэсэн практик суурь хүрээг бүрдүүлж байна. Энэ нь мал аж ахуйд тулгуурласан Монгол Улсын онцлог нөхцөл байдлыг тусган, малчид, фермерүүд, малын эмч нар, хүн эмнэлгийн ажилтнууд, бодлого боловсруулагчид болон олон нийтийн сүлжээний гүйцэтгэх үүргийг тусгасан болно.

Тус стратегийн зөвлөмжүүд нь улсын хэмжээнд хэрэгжиж буй ББТ-тэй тэмцэх одоогийн санаачилгууд дээр тулгуурласан бөгөөд зан үйлд өөрчлөлт бий болгоход нотолгоонд суурилсан мэдээлэл түгээх, үүрэг хариуцлагыг тодорхой болгох, тасралтгүй оролцоог хангахын ач холбогдлыг онцолсон.

Дэлхийн Мал, Амьтны Эрүүл Мэндийн Байгууллага нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон Талт Итгэлцлийн Сан (МРТГ)-гийн хүрээнд түнш байгууллагууд болох НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагатай хамтран энэхүү чухал ажилд Монгол Улсыг дэмжин ажиллаж байгаадаа бахархалтай байна. Энэхүү стратегийг боловсруулахад хувь нэмрээ оруулсан МЭЕГ болон бусад бүх үндэстний байгууллагууд,

экспертүүд, оролцогч талуудад чин сэтгэлийн талархал илэрхийлье. Та бүхний манлайлал нь Монгол Улсын ББТ-тэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлж, бичил биетний эсрэг эмийн үр нөлөөг хадгалах дэлхийн нийтийн хүчин чармайлтад үнэтэй хувь нэмэр оруулж байна.

Энэхүү стратегийг хэрэгжүүлэхэд Дэлхийн Мал, Амьтны Эрүүл Мэндийн Байгууллага нь Монгол Улсыг цаашид ч тууштай дэмжин ажиллах болно. Бид хамтдаа ирээдүй хойч үедээ зориулан олон нийт, мал амьтан болон экосистемийн эрүүл мэндийг хамгаалж чадна.

Др. Томоко Ишибаши

Дэлхийн Мал, Амьтны Эрүүл Мэндийн Байгууллагын Ази, Номхон далайн бүсийн суурин төлөөлөгч

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ

АНМЭГ	Аймаг, Нийслэлийн мал эмнэлгийн газар
АНЭМГ	Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар
ББТ	Бичил биетний тэсвэржилт
ББТСТМХҮС	Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх, тэмцэх мэдээлэл харилцааны үндэсний стратеги
ББЭЭ	Бичил биетний эсрэг эм
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БЯ	Боловсролын яам
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ДМАЭМБ	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МЭЭГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МЭЭШХ	Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн
МЭЭСБУЛ	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын Лаборатори
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ХХААБ	Хүнс, Хөдөө Аж Ахуйн байгууллага
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ОУБ	Олон улсын байгууллага
ӨАУМХ	Өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо
ӨТТ	Өдрийн тунлагдсан тун
САЗ	Стандарт ажиллагааны заавар
СВОТ	Давуу тал, Сул тал, Боломж, Аюулын (СВОТ) шинжилгээ
СХЗГ	Стандарт хэмжил зүйн газар
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилтууд
УХЭШХ	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХАБУЛЛ	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори
ХЭСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭЭХХЗГ	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв

АГУУЛГА

1. ОРШИЛ	10
2. СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ	11
3. БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТТЭЙ ТЭМЦЭЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА	13
4. ББТ-ТЭЙ ТЭМЦЭХ МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН СВӨТ ДҮН ШИНЖИЛГЭЭ	13
5. ЗОРИЛГО:	15
6. ЗОРИЛТ:	15
7. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	16
8. МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ СТРАТЕГИАС ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН	16
9. БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦААНЫ ХҮРЭЭ	17
10. ХЭРЭГЖИЛТ	22
11. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ БА ҮНЭЛГЭЭ	22

ОРШИЛ

Өнөөдөр Дэлхий даяар бичил биетний тэсвэржилт (ББТ) нь хүн, мал, амьтан, ургамал болон хүрээлэн буй орчны эрүүл мэндэд ноцтой заналхийлэл учруулж байна. Энэхүү тулгамдсан асуудалд Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ) нэн даруй хариу арга хэмжээ авах шаардлагатайг хүлээн зөвшөөрч, ББТ-ийг бууруулах чиглэлээр үр дүнтэй, тогтвортой олон улсын хамтын үйл ажиллагааг дэмжих зорилгоор олон талт хамтын ажиллагааны бүлгийг байгуулсан. Мөн НҮБ-ын 2024 оны Ерөнхий Ассамблейн 79 дүгээр чуулганаар Дэлхийн Улс орны удирдагч нар ББТ-тэй тэмцэх талаарх улс төрийн тунхаглалыг баталж, тодорхой зорилтууд болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх амлалт өгсөн.

ББТ-ийн олон талт шалтгаан болон өргөн хүрээний үр дагаврыг харгалзан үзвэл, энэ асуудалтай үр дүнтэй тэмцэхэд цогц мэдээлэл, харилцааны стратеги шаардлагатай. Дэлхийн өнцөг булан бүрд хүн болон мал, амьтны эрүүл мэндийн мэргэжилтнүүд, фермерүүд, малчид, мал аж ахуйн чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгчид, олон нийт болон бүх оролцогч талуудын мэдлэг, хандлага, дадлыг сайжруулахаар анхаарч байна. Манай улсад хүний эрүүл мэндийн салбарт ББТ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр ахиц гарч буй ч, мал эмнэлэг болон байгаль орчны салбарт энэ асуудалд анхаарах шаардлага

өндөр хэвээр байна. ББТ-ийн эрсдэл нь бичил биетний эсрэг эм (ББЭЭ), бодисын хэрэглээ, хяналтыг зохицуулах хууль, эрх зүйн тогтолцоо сул, хэрэгжилт хангалтгүй улс орнуудад өндөр байна. Иймд Монгол Улсад ББТ болон ББЭЭ-ийн хэрэглээтэй холбоотой мэдлэг, мэдээллийг олон талт бүлгүүдэд хүргэх арга хэмжээг энэхүү Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх, тэмцэх мэдээлэл харилцааны үндэсний стратеги (ББТСТМХҮС)-д нэгтгэн тусгаж байна. Уг стратеги нь хүний эрүүл мэнд болон хөдөө аж ахуйн салбар дахь ББЭЭ, бодисын зохистой хэрэглээг бий болгох шаардлагыг тодотгохоос гадна байгаль орчны асуудлыг адил анхаарах ёстойг онцолсон. ББТСТМХҮС нь хүн, мал, амьтны эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуй болон байгаль орчны салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, олон нийтэд чиглэсэн мэдээлэл, харилцааны үйл ажиллагааг зохион байгуулахад чухал ач холбогдолтой чухал гарын авлага юм.

ББТСТМХҮС нь Монгол Улсад ББТ болон ББЭЭ-ийн хэрэглээний өнөөгийн нөхцөл байдал, түүнчлэн ББТ үүсэхэд нөлөөлж буй гол хүчин зүйлсийн үнэлгээнд тулгуурлан боловсруулагдсан бөгөөд ББТ-ийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, шаардлагатай мэдээллийг тогтмол өгөхөд чиглэгдсэн.



Монголын нуурын эрэг дээрх ямааны сүрэг. Эх сурвалж: Getty Images

СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

1929 онд Английн эрдэмтэн Александр Флеминг анхны антибиотик болох пенициллинийг санамсаргүй байдлаар нээснээс хойш хүн төрөлхтөн антибиотикийн эмчилгээг хүн, мал, амьтан өвчний эмчилгээнд өргөн хэрэглэж, нянгийн халдваруудын эсрэг үр дүнтэй тэмцэж ирсэн. Гэвч хүмүүс бидний ББЭЭ-ийн зохисгүй хэрэглээнээс шалтгаалан хүн, мал, амьтны дунд эмэд тэсвэртэй бичил биетэн үүсэж, тархах улмаар хүн эмнэлгийн салбарт өвчний эмчилгээ удаашрах, эмнэлгийн зардал өсөх, нас баралтын түвшин нэмэгдэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Харин мал аж ахуйн салбарт үйлдвэрлэлийн үр ашиг буурах, хүнсний аюулгүй байдал алдагдах, улмаар нийтийн эрүүл мэнд, байгаль, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэх зэрэг олон талт хүндрэлийг бий болгож байна. ББТ-тэй үр дүнтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний нэг нь олон нийтэд мэдээлэл хуваалцах, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хүртээмжтэй зохион байгуулах явдал юм.

Монгол Улсын Хүний эрүүл мэндийн салбар дахь бичил биетний эсрэг эмийн хэрэглээ болон Бичил биетний тэсвэржилтийн тандалт

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох "Алсын хараа-2050"-д эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэх, улмаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог бэхжүүлэх зорилтыг тодорхойлон тусгасан байдаг. Энэхүү зорилтын хүрээнд эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн орчныг үе шаттайгаар сайжруулж байгаа бөгөөд шинэчлэн батлагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд ББТ-тэй тэмцэх, бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг дэмжихтэй холбоотой тодорхой заалтуудыг шинээр тусгасан нь чухал ахиц дэвшил болж байна.

Монгол Улсын хэмжээнд одоогийн байдлаар 56 улсын 740 үйлдвэрлэгчийн 3900 гаруй нэр төрлийн эм бүртгэлтэй байна. Үүнээс 29 улсын 110 үйлдвэрлэгчийн 337 нэр төрлийн импортын нянгийн эсрэг эм, дотоодын 6 үйлдвэрийн 24 нэр төрлийн нянгийн эсрэг эм бүртгэлтэй бөгөөд энэ нь нийт бүртгэлтэй эмийн 9.3 хувийг эзэлж байна. Хэдийгээр эмийн сонголт, хүртээмж өргөжиж байгаа боловч антибиотикийн хэрэглээ дэлхийн дунджаас харьцангуй өндөр хэвээр байгаа нь ББТ үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Иймд иргэд, олон нийт, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зөв, нотолгоонд суурилсан мэдээллийг тогтмол хүргэх, антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь нэн тэргүүний зорилт болж байна.

Мөн Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар Эмийн эмчилгээний хороо болон бичил биетний эсрэг эмийн дэд хорооны ажиллах журмыг шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус журмын хүрээнд тусгай зөвшөөрөл бүхий бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагуудаас (төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, амаржих газар) тайлан мэдээг тогтмол авч, эмийн хэрэглээний хяналт-шинжилгээг сайжруулж байна.

Эмийн эмчилгээний зохицуулах хорооны 2024 оны тайлангийн дүнгээс харахад антибиотикийн хэрэглээний бүтэц тодорхой хэмжээнд өөрчлөгдөж байна. Тухайлбал, цефазолин тарилгын нунтгийн хэрэглээ өмнөх онтой харьцуулахад буурсан бол цефтриаксон 1000 мг тарилгын нунтгийн хэрэглээ нэмэгдсэн байна. Үүнээс гадна левофлоксацин 500 мг болон ципрофлоксацин 500 мг шахмал эмийн хэрэглээ өмнөх оноос ойролцоогоор хоёр дахин өссөн нь анхаарал татах үзүүлэлт юм. Эдгээр өөрчлөлт нь өргөн хүрээний үйлдэлтэй, "хяналттай хэрэглээ"-ний бүлэгт хамаарах антибиотикийн хэрэглээ нэмэгдэж байгааг илтгэж байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас (ДЭМБ) гаргасан зөвлөмжид “хүртээмжтэй хэрэглэх” бүлгийн антибиотикийн эзлэх хувь 60 хувиас доошгүй байхыг зөвлөдөг. Гэвч манай улсын хувьд энэхүү үзүүлэлт 46.6 хувьтай байгаа нь шаардлагатай түвшнээс доогуур байна. Харин “хяналттай хэрэглэх” бүлгийн антибиотикийн хэрэглээ 53 хувьд хүрсэн нь зохистой хэрэглээний зарчим алдагдаж болзошгүйг харуулж байна. Энэ нь цаашид бичил биетний тэсвэржилт нэмэгдэх эрсдэлийг дагуулж болзошгүй тул бодлогын түвшинд онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Иймд антибиотикийн зохистой хэрэглээг дэмжих, эмийн хэрэглээний хяналтыг сайжруулах, эмч мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх, иргэдийн мэдлэг, хандлагыг өөрчлөх цогц арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна. Мөн ДЭМБ-ын зөвлөмжид нийцүүлэн “хүртээмжтэй хэрэглэх” бүлгийн антибиотикийн хэрэглээг нэмэгдүүлж, “хяналттай” болон “нөөц” бүлгийн эмийн зохисгүй хэрэглээг бууруулах бодлогыг тууштай хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Мал эмнэлгийн салбар дахь бичил биетний эсрэг эмийн хэрэглээ болон Бичил биетний тэсвэржилтийн тандалт

Монгол улсын мал, амьтны эмийн асуудлыг Мал эмнэлгийн ерөнхий газар мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Мал, амьтны эм тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн хүрээнд хариуцан ажиллаж байна. Мөн Мал эмнэлгийн ерөнхий газрын дэргэд төрөөс эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий орон тооны бус Мал, амьтны эмийн зөвлөл болон Фармакопейн хороо ажилладаг.

Монгол Улсын мал, амьтны эмийн бүртгэлд 2025 оны 12 дугаар сарын байдлаар 1065 нэр төрлийн эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт бүртгэгдсэн ба үүнээс нянгийн эсрэг эм 200 орчин нэр төрлийг эзэлж байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/356 дугаар тушаалаар батлагдсан “Мал, амьтны эмийг жороор олгох журам”-ын дагуу мал, амьтанд хэрэглэж буй нянгийн эсрэг эмийг жороор олгох зохицуулалт хэрэгжиж эхлээд байна.

Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах мал, амьтны эмийн үлдцийн тандалтыг 2022 оноос, харин тэсвэржсэн бичил биетнийг илрүүлэх тандалтыг 2024 оноос эхлэн жил бүр зохион байгуулж байна. Тус тандалтын үр дүнгээс үзэхэд Монгол орны бэлчээрийн мал аж ахуйн салбарт эмийн хэрэглээ харьцангуй бага байгаа бөгөөд үүний нөлөөгөөр малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд эмийн үлдэгдэл болон тэсвэржсэн бичил биетний эрсдэл бага байгаа нь давуу тал болж байна.

Монгол Улс нь өргөн уудам нутаг дэвсгэртэй бөгөөд малчин ард түмэн нь байгалиа дээдэлж, уламжлалт нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг ба малын тоо толгой нь хүн амын тооноос даруй 20 дахин их байдаг онцлогтой. Хөдөө орон нутагт хүн, мал амьтны эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг нэгж нь зөвхөн суманд байдаг тул алслагдсан бүс нутагт амьдардаг нүүдэлчин малчдын эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байна.

Энэхүү нөхцөл байдал нь малчдад өөрсдөдөө болон малдаа дур мэдэн оношилгоо, эмчилгээ хийх, бичил биетний эсрэг эмийг зохисгүй хэрэглэхэд хүргэх шалтгаан болдог бөгөөд ББТ үүсэх, тархах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн олон нийт, ялангуяа малчдын дунд бичил биетний эсрэг эмийг зохистой хэрэглэх талаарх мэдлэг, мэдээлэл хангалтгүй байгаа нь нөлөөлж байна.

БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТТЭЙ ТЭМЦЭЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ББТ нь эрүүл мэндэд шинээр тулгарч буй ноцтой аюул занал гэдгийг манай улс хүлээн зөвшөөрснөөр Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нар хамтран 2017–2020 болон 2022–2025 онд хэрэгжүүлэх “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г тус тус батлан хамтран хэрэгжүүлсэн ба 2022–2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/521, А/331 дугаарт хамтарсан

тушаалаар салбар дундын орон тооны бус зөвлөл байгуулагдсан.

Улсын Их Хурлын 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль” (шинэчилсэн найруулга) болон “Мал амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль”-ийг тус тус батлан 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн. Дээрх хуулиудад ББТ-тэй тэмцэх, ББЭЭ-ийн зохистой хэрэглээ, хяналттай холбоотой зохицуулалтыг тусгаснаар хууль эрх зүйн орчин илүү боловсронгуй болсон.

ББТ-ТЭЙ ТЭМЦЭХ МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН СВОТ ДҮН ШИНЖИЛГЭЭ

2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулсан ББТ-ийн үндэсний зөвлөлдөх уулзалтын үеэр Монгол Улсад ББТ-ийн чиглэлээр ажиллаж буй гол оролцогч талууд хамтран давуу тал, сул тал, боломж, аюулуудыг тодорхойлсон. Манай

улсын хувьд ББТ-тэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хэд хэдэн давуу тал байгаа ч тодорхой сул тал болон эрсдэлтэй хүчин зүйлүүд нь төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд саад бэрхшээлийг бий болгож

Хүснэгт 1: СВОТ дүн шинжилгээ байна.

(Хүснэгт 1).

Давуу талууд

- Сургалтын орчин, тоног төхөөрөмжийн хүртээмж, чанар сайжирсан.
- ББЭЭ-ийн зохисгүй хэрэглээ болон ББТ-ийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт аажмаар нэмэгдэж байна.
- ББТ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой “Дэлхийн 7 хоног”-ийг тэмдэглэдэг болсон.
- Хүн эмнэлгийн салбарт антибиотикийг зөвхөн жороор олгодог тогтолцоо хэрэгжиж байна.
- ББТ-ийн асуудлыг хууль, журам, стандартуудад тусган хэрэгжүүлж эхэлсэн.

Сул талууд

- Салбар хоорондын уялдаа холбоо, зохицуулалт хангалтгүй байна.
- Бичил биетний тэсвэржилтийн тандалтын тогтолцоо сул хөгжсөн.
- Иргэд ББЭЭ-ийг эмчийн заалтгүйгээр, дур мэдэн хэрэглэх хандлага өндөр байна.
- Холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилт, дагаж мөрдөх ажил хангалтгүй байна.
- Олон нийтийн мэдлэг, хандлага бүрэн төлөвшөөгүй байна.

- ББТ-ийн талаарх үндэсний үйл ажиллагааны 2022-2025 төлөвлөгөө батлагдаж хэрэгжсэн.
- ББТ-тэй холбоотой төсөл, хөтөлбөрүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Олон нийт мэдээлэл хүлээн авах боломж нэмэгдсэн бөгөөд нийгмийн сүлжээ (нүүр ном зэрэг) нь мэдээлэл түгээх үр дүнтэй суваг болж байна.

Боломжууд

- Сургалтын хөтөлбөрөөр дамжуулан чадавх бэхжүүлэх, боломж бүрэн байна.
- Нийгмийн сүлжээний хэрэглээ өндөр байгаа нь мэдээлэл түгээх таатай нөхцөл бүрдүүлж байна.
- Мэдээлэл түгээлтийн хурд сайн, олон нийтэд богино хугацаанд хүргэх боломжтой.
- Мэдээллийн эх үүсвэрүүд хангалттай түвшинд байна.
- Мэргэжилтнүүдийг тогтмол мэдээллээр хангах тогтолцоо бүрэлдэж, салбар хоорондын уялдаа холбоо сайжирч байна.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд эм импортлогчдыг хамруулах боломж нээлттэй байна.
- Нийгмийн сүлжээн дэх нөлөөлөгчид болон мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, мэдлэг мэдээлэл түгээх боломжтой.
- Олон улсын санхүүжилт, хөрөнгө оруулалт татах боломж бүрэн байна.

- Найдвартай, албан ёсны мэдээллийн эх үүсвэр тодорхой бус байна.
- ББТ/ББЭЭ-ийн хэрэглээний талаарх нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүй байна.

Аюулууд

- Хэрэв одооноос бодитой арга хэмжээ авахгүй бол 2050 он гэхэд ББТ-ийн улмаас дэлхий даяар жил бүр 10 сая хүн нас барах эрсдэлтэй.
- Худал мэдээлэл өргөн тархсан нь олон нийтийн буруу ойлголтыг гүнзгийрүүлж байна.
- Тандалт судалгааны чиглэлээр суурь мэдээлэл дутмаг байна.
- Хямд үнэтэй антибиотикийн хяналтгүй, өргөн сонголт хаа сайгүй байгаагаас зохисгүй хэрэглээ нэмэгдэх эрсдэлтэй.
- Холбогдох талуудын хоорондын харилцан ойлголцол, уялдаа холбоо сул байна.
- ББТ-ийн бодит эрсдэл, хор уршгийн талаарх үнэн зөв, нотолгоонд суурилсан мэдээлэл олон нийтэд хангалттай хүрэхгүй байгаа явдал юм.

СВОТ шинжилгээний үр дүнгээс харахад дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

Давуу талд ББТ-ийн аюулыг албан ёсоор хүлээн зөвшөөрч эрх зүйн зохицуулалтад тусгасан байдал, олон нийтэд мэдлэг олгох ажлын эхлэл, хэрэгжиж буй хөтөлбөрүүд, хангалттай сургалтын орчин, олон улсын байгууллагуудаас ирдэг тогтвортой дэмжлэг, мэдээлэл түгээх тогтсон сүлжээ зэрэг багтана.

Харин анхаарал шаарддаг сул тал болон аюулд оролцогч талуудын хоорондын хамтын ажиллагаа сул, ББТ болон холбогдох асуудлын талаарх мэдлэг мэдээлэл хомс, хүний нөөц дутмаг, олон улсын санхүүжилтээс өндөр хамааралтай байдал, тандалтын нэгдсэн тогтолцоо сул, худал мэдээллийн тархалт зэрэг асуудлууд орно.

Эдгээр сорилтыг шийдвэрлэх боломжуудаас дурдвал: малчид болон тодорхой нийгмийн бүлгүүдийн хооронд мэдээлэл харилцааны үр ашигтай сүлжээг ашиглах, нийгмийн сүлжээнд түгээх чанартай контент боловсруулж хүргэх, оролцогч талуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, хууль, журмыг боловсронгуй болгох, сургалтын хөтөлбөрүүдийг өргөжүүлэх зэрэг нь онцгой чухал юм.

ЗОРИЛГО:

Энэхүү стратегийн зорилго нь “Нэг эрүүл мэнд” аргачлалд суурилсан мэдээлэл, харилцааны нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх болон тэмцэх чиглэлээр оновчтой мэдээлэл түгээж бичил биетний тэсвэржилтийн эрсдэлийг бууруулахад оршино.

ЗОРИЛТ:

1. Олон нийт, холбогдох салбарын мэргэжилтнүүд болон шийдвэр гаргагчдын ББТ-ийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг дээшлүүлэх;
2. ББТ-тэй тэмцэх мэдээлэл харилцааны үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо, харилцан дэмжлэгийг бэхжүүлэх;
3. Мэдээлэл харилцааны сувгууд болон арга замыг тодорхойлж, олон нийтэд чиглэсэн ББТ-ийн талаарх нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 1. Нөлөөллийн үйл ажиллагаа:** Олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэл харилцааны арга замыг сайжруулан ББТ-тэй тэмцэх үйл ажиллагааг дэмжих.
- 2. Чадавч бэхжүүлэх:** ББТ-тэй холбоотой сорилтуудыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд гол оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэхэд анхаарах.
- 3. Мэдээлэл харилцааны материал боловсруулах, түгээх:** ББТ-ийн талаарх мэдээллийг үр дүнтэй түгээж, оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор чанартай, ойлгомжтой мэдээлэл харилцааны материалыг боловсруулж нэвтрүүлэх.
- 4. Санхүүжилт болон нөөц бүрдүүлэх:** ББТ-тэй тэмцэх арга хэмжээ, санаачилгыг тогтвортой дэмжихийн тулд шаардлагатай санхүүжилт, нөөц, дэмжлэгийг бүрдүүлэх.

Стратегийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бодлого боловсруулагчид болон хөгжлийн түншүүдийн тасралтгүй анхаарал, идэвхтэй дэмжлэг нэн чухал. Энэ хүрээнд шаардлагатай санхүүжилт, техникийн болон хүний нөөцийн дэмжлэг үзүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах, мэргэжлийн туршлага, мэдлэгийг хуваалцах нь онцгой ач холбогдолтой.

Олон улсын салбар дундын “Дөрвөн талт” хамтарсан ажлын алба (ДЭМБ, ДМАЭМБ, НҮБ-ын ХХААБ, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр) нь Засгийн газрын боломж, нөөцийг үр ашигтай ашиглахад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хөгжлийн түншүүд болон хувийн хэвшлийн хувь нэмрийг татан төвлөрүүлж, энэхүү стратегийн хэрэгжилтийг зохицуулах болон уялдуулах үүрэгтэй.

МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ СТРАТЕГИАС ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

- Оролцогч талууд нь ББТ-ээс үүдэх аюул, эрсдэлийг бүрэн ухамсарлаж, түүнээс урьдчилан сэргийлэх болон тэмцэх бодит арга хэмжээг хэрэгжүүлдэг болно.
- Иргэд, олон нийт, малчид, фермерүүд, эмч, эрүүл мэндийн ажилчид, эмийн мэргэжилтэн зэрэг оролцогч талуудын ББТ-ээс бодисыг хариуцлагатай, зохистой хэрэглэх талаар мэдлэг, ойлголт, хандлага, дадал сайжирна.
- Шийдвэр гаргагч болон бодлого боловсруулагчдын анхаарлыг ББТ-ээс сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хандуулан, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтад эерэг нөлөө үзүүлнэ.
- Монгол Улсад ББТ-ийн эсрэг үйл ажиллагаа ил тод, үр дүн хэмжигдэхүйц болж хандивлагч байгууллагуудтай тогтвортой, үр дүнтэй хамтран ажиллах таатай нөхцөл бүрдэнэ.

ОРОЛЦОГЧ ТАЛУУД

ББТСТМХҮС-ийн үйл ажиллагаанд оролцогчид нь дараах талуудаас бүрдэнэ. Үүнд:

- Бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид;
- Эрүүл мэндийн салбарын ажилтнууд, хүний эмч, малын эмч, малын бага эмч;
- Эм зүйч, эм найруулагчид;
- Эм үйлдвэрлэгчид;
- Малчид, фермерүүд;
- Байгаль орчин, ургамал хамгаалал, газар тариалангийн салбарын мэргэжилтнүүд;
- Малын тэжээл, нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид;
- Хүнс үйлдвэрлэгчид;
- Сургалт, эрдэм шинжилгээний байгууллагууд;
- Мэргэжлийн холбоод;
- Иргэд, олон нийт;
- Олон улсын байгууллагууд;
- Хэвлэл мэдээллийн төлөөлөл.

БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦААНЫ ХҮРЭЭ

Зорилтот бүлэг	Хүрэх үр дүн	Өгөх мэдээллийн агуулга	Мэдээлэл өгөх суваг, зохиогдох арга хэмжээ	Мэдээллийн материал, хэрэгсэл
Иргэд, олон нийт	<p>ББТ-ийн талаарх мэдлэг, хандлага, дадал дээшилж, ББЭЭ-ийг зөвхөн эмчийн заалтаар хэрэглэж хэвшсэн байна.</p>	<ul style="list-style-type: none"> - ББТ нь эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийн нэг. - ББЭЭ-ийг зөвхөн жор, заалтын дагуу хэрэглэх нь өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаална. - ББЭЭ-ийг дур мэдэн хэрэглэх, бусадтай хуваалцах нь эрсдэлтэй. - ББЭЭ-ийг зөвхөн эмийн сангаас, баталгаатай өх үүсвэрээс авах. - ББЭЭ-ийг хувь хүнээс бүү худалдан ав. - ББЭЭ-ийг жорын дагуу заасан хугацааны дагуу ууж хэрэглэх - Халдвараас сэргийлэхийн тулд вакцинд хамрагдаарай. - Хөнгөн хэлбэрийн ханиад, вирусийн халдварын үед антибиотик хэрэглэх шаардлагагүй. - Антибиотик нь вирусийн халдварыг эмчлэхгүй, зөвхөн нянгийн халдварын үед үр дүнтэй. - Эрүүл ахуйн дэглэмийг мөрдөөрэй. - Антибиотик зохистой хэрэглэх нь ББТ-ийг бууруулна. - Хүнсийг цэвэр орчинд бэлтгэж хадгалах 	<ul style="list-style-type: none"> - Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх талаар олон нийтийн мэдлэг хандлага дээшлүүлэх дэлхийн 7 хоног - Дэлхийн малын эмч нарын өдөр - Нийгмийн цахим сүлжээ - Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз, радио) - Сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа 	<ul style="list-style-type: none"> - Мэдлэг, хандлага, дадал тодорхойлох судалгаа - Тараах материал, самбар, нийтлэлүүд

<p>Малчид, фермерүүд</p>	<p>Мал, амьтанд ББЭЭ-ийг зохистой, хариуцлагатай хэрэглэх дадал төлөвшсөн байна.</p>	<ul style="list-style-type: none"> - ББТ нь эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийн нэг. - Малын эмчийн заасан зааврын дагуу ББЭЭ-ийг хэрэглэнэ. - Хүнсний үйлдвэрлэлд эрүүл ахуйн сайн далдыг нэвтрүүлэх. - Мал, амьтанд бичил биетний эсрэг эмийг жор зааврын дагуу хэрэглэж хүнсний аюулгүй байдлыг хангах - ББТ нь амьтан хүн, хүнээс амьтанд дамжиж болох тул ариун цэврийн дадлыг баримталж, эрсдэлийг багасгана. - Та нийгэмд аюулгүй хүнс нийлүүлэхэд чухал үүрэгтэй. - Биоаюулгүй байдлын стандартыг дагаж мөрдөх - Өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд мал, амьтныг вакцинжуулах - Антибиотикийг баталгаатай эх сурвалж, эмийн сангаас авах - Эмийн үлдэцгүй, бичил биетний тэсвэржилтийн эрсдэлгүй эрүүл, аюулгүй хүнс ханган нийлүүлдэг сайн туршлагаа хуваалцах. - Малчид, фермерүүд мал, амьтанд ББЭЭ-ийг хэрэглэхийн өмнө заавал малын эмчтэйгээ зөвлөлд - ББЭЭ-ийг зөвхөн найдвартай эх үүсвэрээс авах - ББЭЭ-ийг урьдчилан сэргийлэх буюу өсөлт дэмжих зорилгоор хэзээ ч бүү хэрэглэ - ББЭЭ-ийг хариуцлагатай хэрэглэхийн чухлыг бусад малчид, фермерүүд, олон нийтэд хэлж ойлгуулах - ББТ нь танд болон таны мал, амьтанд урт хугацааны, өртөг өндөртэй эмчилгээ шаардагдах нөхцөл үүсгэнэ. - ББЭЭ-д тэсвэртэй нянгууд хувь хүний ажил мэргэжил, нас хүйс, нийгмийн байдлыг үл харгалзан бүгдийг нь халдварлуулж чадна. 	<ul style="list-style-type: none"> - Олон нийтийн оролцоо - Үндэсний болон орон нутгийн хэвлэл мэдээлэл - Малчин өрх, ферм дээр очиж уулзах - Малчид, фермерүүдэд чиглэсэн өдөрлөг, арга хэмжээ, үзэсгэлэн худалдаа - Орон нутгийн радио, телевизийн сувгууд - Нэр хүндтэй уран бүтээлчидтэй хамтран ажиллах - Сургуулийн хүүхдээр дамжуулан эцэг эх малчдад мэдээлэл хүргэх - Малчдын холбоо, хоршоодоор дамжуулах - Тариаланчдын байгууллага 	<ul style="list-style-type: none"> - Видео шторк, рийл танилцуулга - Мэдээлэл танин мэдэхүйн тараах материал - Сургалт - Биоаюулгүй байдлын постер - Сурталчилгааны хэрэгслүүд
--------------------------	--	--	---	---

<p>Хүн, малын эрүүл мэндийн салбарын ажилтнууд (хүний их эмч, малын эмч, малын бага эмч)</p>	<p>ББЭЭ-ийг нотолгоонд суурилан, ёс зүйтэй бичиж олгох, өвчтөнд зөв хэрэглээний талаар бүрэн зөвлөгөө өгөх тогтолцоо бэхэжсэн байна.</p>	<ul style="list-style-type: none"> - ББТ нь Дэлхийн хүн, мал, амьтан, байгаль орчны эрүүл мэндийн асуудал юм. - ББЭЭ-ийн жор бичихийн өмнө зайлшгүй шаардлагатай эсэхийг үнэлэх. - Эмчилгээний батлагдсан удирдамжид тулгуурлан жор бичих. - Антибиотик хэрэглэх шаардлагагүй тохиолдолд хэрэглэхээс зайлсхийх - Өвчтөн, малчдад ББЭЭ-ийн зохистой хэрэглээний талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх - Мал, амьтанд хориглосон жагсаалтыг харгалзан, мал амьтанд жор бичих - ББЭЭ-ийн зохисгүй хэрэглээ нь супер бактери үүсэхэд хүргэдгийг таниулах 	<ul style="list-style-type: none"> - Сургалт зохион байгуулах - Үндэсний болон орон нутгийн хэвлэл мэдээлэл - Мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх - Биечлэн очиж ярилцах - Сургуулиудаар очих - Намрын ногоон өдөрлөг - Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр 	<ul style="list-style-type: none"> - Тараах материал - Постер - Сургалтын хөтөлбөр - Телевиз, радиогийн хэлэлцүүлэг - Стандарт ажиллагааны заавар, гарын авлага
<p>Байгаль орчин, ургамал, газар тариалангийн салбарын мэргэжилтнүүд</p>	<ul style="list-style-type: none"> - ББЭЭ, бодисын хаягдлын менежмент ба хөдөлмөрийн аюулгүй байдал сайжирсан байна. - Хүрээлэн буй орчинд ББТ хэрхэн нөлөөлөх талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн байна. 	<ul style="list-style-type: none"> - ББЭЭ, бодисын хаягдал нь хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтны эрүүл мэндэд нөлөөлдөг. - Хүн, малын болон үйлдвэрлэлийн хаягдлын буруу менежмент ББТ-ийг нэмэгдүүлдэг. - Ургамал, газар тариаланд хортон шавж устгах бодис хэрэглэхээс өмнө бусад аргуудыг туршиж үзэх 	<ul style="list-style-type: none"> - Үндэсний болон орон нутгийн хэвлэл мэдээлэл - Вэб сайт эсвэл цахим сургалтууд - Үндэсний болон орон нутгийн түвшний сургалт - Телевиз/радиогийн хэлэлцүүлэг - Мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> - Тараах материал - Постер - Сургалтын хөтөлбөр - Телевиз, радиогийн хэлэлцүүлэг - Стандарт ажиллагааны заавар, гарын авлага
<p>Хүн, мал эмнэлгийн эм зүйчид</p>	<ul style="list-style-type: none"> - ББЭЭ-ийг хариуцлагатай олгох - Үйлчлүүлэгчдэд ББЭЭ-ийг зохистой хэрэглэх талаар зөвлөгөө өгөх 	<ul style="list-style-type: none"> - ББЭЭ-ийг зөвхөн эмчийн жороор олгох - Үйлчлүүлэгчдэд ББЭЭ-ийн зөв зохистой хэрэглээний талаар зөвлөгөө өгөх, зохисгүй хэрэглэснээс үүдэх эрсдэлийг тайлбарлах - ББТ нь хүн, амьтан, ургамал болон хүрээлэн буй орчны эрүүл мэндийн дэлхий нийтийн асуудал гэдгийг таниулах - ББЭЭ-ийг зохисгүй хэрэглэх нь ББТ үүсэх гол шалтгаан юм 	<ul style="list-style-type: none"> - Сургалт, чадавх бэхжүүлэх семинар зохион байгуулах - Үндэсний болон орон нутгийн хэвлэл мэдээлэл - Нийгмийн сүлжээ - Телевиз, радиогийн хэлэлцүүлэг 	<ul style="list-style-type: none"> - Тараах материал - Постер, рийл, хэвлэмэл хуудас - Сургалтын материал болон хичээлүүд - Сургалтын хөтөлбөр

Эм үйлдвэрлэгчдэд	<ul style="list-style-type: none"> - Эм үйлдвэрлэлийн зохистой дадлыг хэрэгжүүлсэн байна. - Үйлдвэрлэл хаягдлын менежмент сайжирч, ББТ-д ээлтэй үйлдвэрлэл төлөвшсөн байна. - ББЭЭ-ийг орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх чиг хандлагатай болсон байна. 	<ul style="list-style-type: none"> - ББЭЭ-ийн хаягдлыг зохистой удирдах, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх арга хэмжээг дагаж мөрдөх - Эмийн импорт, үйлдвэрлэл, түгээлт, хаягдлын зааврыг дагаж мөрдөх - ББЭЭ-ийг орлох бүтээгдэхүүний ашиг тусыг таниулах 	<ul style="list-style-type: none"> - Орлогч талуудтай зөвлөлдөх уулзалт - Үйлдвэрлэгчдэд зориулсан чадавх бэхжүүлэх семинарууд - Хэлэлцүүлэг 	<ul style="list-style-type: none"> - Хэвлэмэл хуудас, тараах материал - Постер - Сургалтын материал болон хичээлүүд - Олон улсын эмийн үйлдвэрүүдийн сайн туршлага
Малын тэжээл үйлдвэрлэгчид	<ul style="list-style-type: none"> - Малын тэжээлийн хариуцлагатай үйлдвэрлэл бий болсон байна. 	<ul style="list-style-type: none"> - ББТ бол эрүүл мэндэд учирч буй эрсдэл - ББЭЭ-ийг тэжээлд нэмэхийг хатуу хориглох - Тэжээл үйлдвэрлэгчид, антибиотикийн үр дүнтэй байдал болон хүртээмжийг хадгалахад чухал үүрэгтэй. - Таны манлайлал ББТ-тэй тэмцэхэд чухал үүрэгтэй. 	<ul style="list-style-type: none"> - Сургалт, чадавх бэхжүүлэх - Үндэсний болон орон нутгийн хэвлэл мэдээлэл - Булгээр хэлэлцүүлэх 	<ul style="list-style-type: none"> - Хэвлэмэл хуудас, тараах материал - Видео шторк - Постер
Сургалт, эрдэм шинжилгээний байгууллагууд	<ul style="list-style-type: none"> - Судалгаа шинжилгээ хийж, нотолгоонд суурилсан мэдээллээр бодлого боловсруулагч, олон нийтийг хангасан байна. - ББТ талаарх оновчтой сургалтын хөтөлбөр боловсруулагдсан байна. 	<ul style="list-style-type: none"> - ББТ-ийн нотолгоонд суурилсан судалгааг нэмэгдүүлж, тоон мэдээлэлтэй болох - Судалгааны үр дүнг бодлогод тусгахын тулд шийдвэр гаргагчидтай хамтрах - ББТ сургалтын хөтөлбөрийн зайлшгүй хэсэг болгох - Дэлхийн өнцөг булан бүрээс судлаачдыг урьж, ББТ шийдэх арга замын талаар санаа бодлоо хуваалцах 	<ul style="list-style-type: none"> - Хэлэлцүүлэг - Хамтын ажиллагааны уулзалт - Судалгааны аялал 	<ul style="list-style-type: none"> - Тайлангууд - Үнэлгээний материалууд - Шинжлэх ухааны нийтлэлүүд - Олон улсын жишиг сургалтын хөтөлбөр
Мэргэжлийн холбоод	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн холбоодын үйл ажиллагааны хөтөлбөрт ББТ-ийн асуудал орсон байна - ББТ-тэй холбоотой асуудлаар сурталчлах, нөлөөлөх ажил хийсэн байна. 	<ul style="list-style-type: none"> - ББТ-ийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд мэргэжлийн холбоод, хэрэглэгчдийн бүлэг чухал үүрэг гүйцэтгэж манлайлан ажиллах. - ББЭЭ-ийн зохистой хэрэглээг төлөвшүүлснээр ББТ-тэй тэмцэх боломжтой. 	<ul style="list-style-type: none"> - Сургалт, чадавх бэхжүүлэх семинар зохион байгуулах - Үндэсний болон орон нутгийн хэвлэл мэдээлэл - Сургуульд зочилж мэдээлэл өгөх - Малчид, фермерүүдэд чиглэсэн өдөрлөг, арга хэмжээ, үзэсгэлэн худалдаа - Мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> - ББТ-тэй холбоотой мэргэжлийн тасралтгүй сургалт болон цахим хичээлүүд - Бодлогын бичиг баримт

Бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид	ББТ-ийг бууруулах үйл ажиллагаанд засаглал чадавх бэхэжнэ.	<ul style="list-style-type: none"> - ББТ нь хүн, амьтан, ургамал болон хүрээлэн буй орчны эрүүл мэндэд нөлөөлөх дэлхийн хэмжээний аюул болоод байна - "Нэг эрүүл мэнд" хамтын ажиллагаа нь урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үр дүнтэй арга - Салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжих - Нотолгоонд суурилсан, салбар хоорондын оролцоотой бодлого боловсруулах - Одоо арга хэмжээ авахгүй бол ирээдүйд ноцтой хохирол учирна. 	<ul style="list-style-type: none"> - Сургалтууд - Гарын авлага - Хамтын ажиллагааны уулзалтууд - ББТ-тэй тэмцэх дэлхийн 7 хоног (WAAW) 	<ul style="list-style-type: none"> - Бодлогын бичиг баримт - Танилцуулга, гарын авлага, сургалтын материал, дүрс бичлэгийн материалууд
Хөгжлийн түншүүд, хандивлагчид, олон улсын байгууллагууд	ББТ-ийн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт бэхэжнэ.	<ul style="list-style-type: none"> - Нөхөн сэргээлт, санхүүгийн дэмжлэг - Өндөр эрсдэлтэй бүс нутагт дэмжлэг үзүүлэх - Салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг дэмжих хэрэгтэй - Санхүүжилт, нөөц бүрдүүлэлтийг тогтвортой хангах - Судалгаа, нотолгоо дутмаг чиглэлүүдэд дэмжлэг үзүүлэх 	<ul style="list-style-type: none"> - Нөөц бүрдүүлэлттэй холбоотой үндэсний сургалт, семинарууд 	<ul style="list-style-type: none"> - Тайлангууд - Нөөц бүрдүүлэлтийн стратеги - Түншүүд, донорууд болон ТББ-уудын газрын зураг/ жагсаалт

* Дэлгэрэнгүй мэдээлэл харахыг хүсвэл дараах QR кодыг ашиглана уу.



ХЭРЭГЖИЛТ

Мэдээлэл, харилцааны стратегийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд байгууллага бүр бичил биетний тэсвэржилт (ББТ)-тэй тэмцэх мэдээлэл, харилцааны үйл ажиллагааг хариуцах тодорхой албан тушаалтан томилох, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой ажлыг тусган хэрэгжүүлдэг байх шаардлагатай. Энэ нь үйл ажиллагааны тогтвортой, хариуцлагатай хэрэгжүүлэх, стратеги хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийж боломжийг бүрүүлэх үндэс болно.


Түүнчлэн салбар хоорондын түншлэл нь ББТ-ийн чиглэлээрх мэдээлэл, харилцааны цогц стратегийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Холбогдох байгууллагуудтай хамтран ажилласнаар үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, олон нийтийн болон байгууллагын нэр хүндийг бэхжүүлэх, мөн дундын санхүүгийн болон бусад нөөцийг бүрдүүлэх боломж бүрдэнэ.

Мэдээлэл, харилцааны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлэхэд Монгол Улсад Олон талт хамтын ажиллагааны итгэлцлийн сангаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд бодит боломж олгож байна. Мөн Монгол Улсад мэдээлэл, харилцааны стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавх бэхжүүлэх чиглэлээр НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага (FAO), НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP), Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (WHO), Дэлхийн Мал, Амьтны Эрүүл Мэндийн Байгууллага (WOAH) дэмжлэг үзүүлж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ БА ҮНЭЛГЭЭ

Бичил биетний тэсвэржилт (ББТ)-тэй тэмцэх мэдээлэл, харилцааны стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг нь хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ) бөгөөд энэ нь нийгэм, зан үйлийн өөрчлөлтийг дэмжих үйл ажиллагааны салшгүй хэсэг юм. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь мэдээлэл, харилцааны үйл ажиллагааны үр нөлөө, үр дүнг бодитой үнэлэх, стратеги төлөвлөсөн зорилгодоо хүрч байгаа эсэхийг тодорхойлох боломжийг бүрдүүлнэ. Иймд мэдээлэл, харилцааны үйл ажиллагааны нөлөөг цаг хугацааны явцад хэмжих тодорхой шалгуур, үзүүлэлтүүдийг тогтоох шаардлагатай. Үүнд антибиотикийн хэрэглээтэй холбоотой зан үйлийн өөрчлөлтийг хянах, зорилтот бүлгүүдийн мэдлэг, хандлагын түвшнийг үнэлэх судалгаа, үнэлгээний үйл ажиллагаа багтана.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний боловсрон-гүй тогтолцоог хэрэгжүүлснээр оролцогч талууд мэдээлэл, харилцааны үйл ажиллагааны үр дүнгийн талаар бодит ойлголт авч, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, нөөцийг оновчтой хуваарилах, стратегийг тасралтгүй сайжруулах боломж бүрдэнэ.



БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТЭЭС СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ (ББТСТМХҮС) – (2027-2030) БОЛОВСРУУЛСАН БАГ БҮРЭЛДЭХҮҮН.



ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨХ:

Dr. Pondpan Suwanthada, ДМАЭМБ-ын Ази-Номхон далайн бүсийн
Бичил биетний тэсвэржилт хариуцсан ажилтан;

Basilio Valdehuesa, ДМАЭМБ-ын Ази-Номхон далайн бүсийн
Мэдээлэл харилцааны ажилтан.

ҮНДЭСНИЙ БАГ:

С.Батсайхан, ДМАЭМБ-ын Үндэсний зөвлөх;

Т. Тунгалаг, МЭЕГ, Мал, амьтны эм, биобэлдмэл, тэжээлийн нэмэлт, эмнэлгийн хэрэгслийн хяналтын
асуудал хариуцсан мал эмнэлгийн улсын ахлах байцаагч;

Б.Баяртунгалаг, МЭЕГ-ын Сургалт, итгэмжлэлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн;

Ч.Лувсанжанцан, МЭЕГ-ын Мал, амьтны эмийн үйлдвэрлэл, хэрэглээний асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн;

Л.Дулмаа, ЭЭХХЗГ-ын Аюулгүй байдал, тандалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч;

Б.Энхтөр, НҮБ-ын ХХААБ-ын АСТ төслийн үндэсний зохицуулагч;

НАРИЙН БИЧИГ:

Э.Мөнхбаяр, МЭЕГ-ын Мал, амьтны эмийн үлдэгдлийн хяналт, эм, биобэлдмэлийн асуудал хариуцсан
мэргэжилтэн;

С.Ганболор, ЭЭХХЗГ-ын Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээний асуудал хариуцсан
мэргэжилтэн.

АНТИБИОТИК БОЛОН БУСАД БИЧИЛ БИЕТНИЙ ЭСРЭГ ЭМИЙГ ЖОРЫН ДАГУУ ХЭРЭГЛЭХГҮЙ БОЛ БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТ* ҮҮСНЭ.

ИНГЭСНЭЭР АЛИВАА
ӨВЧНИЙГ ЭМЧЛЭХЭД
УЛАМ ХЭЦҮҮ
БОЛОХЫН ЗЭРЭГЦЭЭ
ДАРААХ АСУУДЛУУД
ТУЛГАРДАГ:

- ЭРҮҮЛ МЭНДИЙН
ЗАРДАЛ ИХСЭХ
- ЭМНЭЛГИЙН ОР
ХОНОГ УРТСАХ
- НАС БАРАЛТАД
ХҮРЭХ



МЭДЛЭГ ОЛГОЁ. НӨЛӨӨЛЬЕ. ЯГ ОДОО.






МЭДЛЭГ ОЛГОЁ. НӨЛӨӨЛЬЕ. ЯГ ОДОО.



- Антибиотик болон бусад бичил биетний эсрэг эмийг зөвхөн жороор олгоно.
- Антибиотикийг зөвхөн эмнэлгийн мэргэжилтэн зөвлөснөөр бүрэн хугацааны дагуу хэрэглээрэй.
- Өмнөх эмчилгээнээс үлдсэн антибиотикийг хэрэглэхгүй, бусадтай хуваалцаж болохгүй.
- Бичил биетний эсрэг эмийг хариуцлагатай хэрэглээрэй.



МЭДЛЭГ ОЛГОЁ. НӨЛӨӨЛЬЕ. ЯГ ОДОО.



БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТИЙН ЭСРЭГ БИД ХАМТДАА!

БИДНИЙ ЭРҮҮЛ МЭНД МАЛ АМЬТДЫН ЭРҮҮЛ
МЭНД БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНООС
ШУУД ХАМААРАЛТАЙ.



МЭДЛЭГ ОЛГОЁ. НӨЛӨӨЛЬЕ. ЯГ ОДОО.



ТАНЫ ТУСЛАЛЦАА ХЭРЭГТЭЙ

Бид бүгдээрээ
оролцох
үүрэгтэй!

— ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ —
АНТИБИОТИКИЙН
— СУРТАЛЧЛАХАД —



Ивээн тэтгэгч:



World Organisation
for Animal Health
Founded as OIE

Хэрэгжүүлэгч:



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ТАНЫ ТУСЛАЛЦАА ХЭРЭГТЭЙ

ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ
АНТИБИОТИКИЙН
СУРТАЛЧЛАХАД



ТЭМЦЬЕ

#НЯНГИЙН ТЭСВЭРЖИЛТИЙН ЭСРЭГ

- Антибиотикийг хяналтгүй эсвэл хэтрүүлэн хэрэглэх нь нянгийн тэсвэржилтийг үүсгэж, хүн болон малын эрүүл мэнд, тавлаг байдлыг алдагдуулах эрсдэл дагуулж байна
- Гэхдээ та бид АНТИБИОТИКИЙГ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭСНЭЭР эмийн үйлчилгээг нь хадгалахад туслаж чадна.

Ивээн тэтгэгч:



World Organisation
for Animal Health
Founded as OIE

Хэрэгжүүлэгч:



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

 Антибиотик нь зайлшгүй шаардлагатай эм учраас

 Халдварыг устгах чадвараа хадгалахад нь тусалцгаая

БҮГДЭЭРЭЭ БАРИМТЛАХ “ЗӨВХӨН” 5 ЗАРЧМУУД

1



Антибиотикийг зөвхөн малын эмчийн жороор хэрэглэнэ

2

Антибиотикууд бүх халдварыг устгаж чадахгүй учраас зөвхөн шаардлагатай тохиолдолд хэрэглэнэ



3



Зөвхөн жорын дагуу, тохирсон тун хэмжээгээр хэрэглэнэ үү

4

Зөвхөн зөвшөөрөгдсөн эмийн сангуудаар худалдаална



5



Зөвхөн вакцинжуулалт болон эрүүл ахуйн сайн дадалтай хослуулан хэрэглэнэ үү



ТАНЫ
ОРОЛЦОО
ХЭРЭГТЭЙ
БАЙНА

“ ХЭРЭГЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛӨН
ТА ТУСАЛЖ ЧАДНА
БИД БҮГДЭЭРЭЭ
ОРОЛЦОХ ҮҮРЭГТЭЙ ”



Ивээн тэтгэгч:



World Organisation
for Animal Health
Founded as OIE

Хэрэгжүүлэгч:



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

АНТИБИОТИКИЙН ХАРИУЦЛАГАТАЙ БОЛОН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ МАЛ ЭМНЭЛЭГТ

АНТИБИОТИКИЙН АНАГААХ ЧАДВАРЫГ ХАДГАЛАХ НЬ



**МАЛЫН
ЭРҮҮЛ МЭНД**
Дэлхийд Малын гаралтай түүхий эд
бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн алдалын
> 20% нь малын өвчнөөс болж байна



**МАЛ АМЬТДЫН
ТАВЛАГ БАЙДАЛ**
Малын эрүүл мэнд нь
Мал амьтны тавлаг байдлын
гол үзүүлэлт нь юм



**ХҮНСНИЙ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ**
2050 он гэхэд малын гаралтай
уургийн бүтээгдэхүүн одоогийнхоос
> 70% хувирч нэмэгдэнэ



**НИЙТИЙН
ЭРҮҮЛ МЭНД**
Хүний өвчний > 60%
хувь нь мал амьтдаас халдварладаг



ДЭЛХИЙН МАЛ АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН СТАНДАРТ ТОГТООХ НЬ

АНТИБИОТИКИЙН ХЭРЭГЛЭЭ
БОЛОН ТАНДАЛТ

МАЛ ЭМНЭЛГИЙН
ЭРХЗҮЙН ОРЧИН

МАЛ ЭМНЭЛГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

ХУУРАЙ ГАЗРЫН БОЛОН
УСНЫ АМЬТДЫН СТАНДАРТ

WORLD ANTI-BIOTIC AWARENESS WEEK
www.oie.int/antimicrobial-resistance
#AntibioticResistance

Ивээн тэтгэгч:
 World Organisation
for Animal Health
Founded as OIE

Хэрэгжүүлэгч:
 ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

АНТИБИОТИКИЙН

ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ
СУРТАЛЧЛАХАД

World AMR Awareness Week (WAAW)

Арван нэгдүгээр сар 18 -24

**БИД
БҮГДЭЭРЭЭ
ОРОЛЦОХ
ҮҮРЭГТЭЙ!**



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



UN Multi-Partner
Trust Fund Office



World Organisation
for Animal Health
Founded in 1924



Антибиотик нь зайлшгүй шаардлагатай эм учраас



Халдварыг устгах чадвараа хадгалахад нь тусалцгаая

БҮГДЭЭРЭЭ "ЗӨВХӨН" 5 ЗАРЧМЫГ БАРИМТАЛЪЯ

1

Антибиотикийг зөвхөн малын эмчийн жороор хэрэглэнэ

2

Антибиотикууд бүх халдварыг устгаж чадахгүй учраас зөвхөн шаардлагатай тохиолдолд хэрэглэнэ

3

Зөвхөн жорын дагуу, тохирсон тун хэмжээгээр хэрэглэнэ үү

4

Зөвхөн зөвшөөрөгдсөн эмийн сангаас худалдан авъя

5

Зөвхөн вакцинжуулалт болон эрүүл ахуйн сайн дадалтай хослуулан хэрэглэнэ үү

ХЭРЭГЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛӨН

ТА ТУСАЛЖ ЧАДНА БИД БҮГДЭЭРЭЭ ОРОЛЦОХ ҮҮРЭГТЭЙ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



UN Multi-Partner
Trust Fund Office



World Organisation
for Animal Health
Founded in 1924

